





"ШИНЭ ХОВД - 2030" ХӨГЖЛИЙН ШИНЭ ШАТАНД

ХҮРГЭХ ТӨСЛҮҮД

- Үйлдвэрлэлийн-29 төсөл
- ХАА-н үйлдвэрлэл- 13 төсөл
- Дэд бүтцийн- 9 төсөл
- Үйлчилгээ, аялал- 8 төсөл
- Нийгэм, хотын хөгжил-8 төсөл
- НИЙТ- 67 ТӨСӨЛ

"ШИНЭ ХОВД" ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК
"ШИНЭ ХОВД АГРО ПАРК"- ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БҮС
ШИНЭ ХОВДЫН ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ
ШИНЭ ХОВДЫН ЭКО ЦЕМЕНТИЙН ҮЙЛДВЭР
"ШИНЭ ХОВД" ОЛОН УЛСЫН НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ
ШИНЭ ХОВДЫН ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ
ШИНЭ ХОВДЫН ШИНЖЛЭХ УХААН, ИННОВАЦИЙН СУДАЛГААНЫ ТӨВ
ШИНЭ ХОВДЫН КЕМБРИДЖИЙН СУРГАЛТТАЙ СУРГУУЛЬ
ШИНЭ ХОВД ИХ СУРГУУЛЬ
ШИНЭ ХОВДЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ- СЭТГЭЛ ТАТАМ ХОВД
ШИНЭ ХОВД ХОТЫН ХӨГЖИЛ
ШИНЭ ХОВДЫН ШИНЭ СУМД

АЛСЫН ХАРАА

Олон тулгуурт, бие даасан эдийн засгийн ногоон хөгжлийн загвар аймаг болно.

ХОВД АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ЗОРИЛТ "ШИНЭ ХОВД" ХӨГЖЛИЙН ТӨСЛҮҮД

ХӨГЖЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ:

- ✓ Мал аж ахуйн гаралтай түүхийн эдийн боловсруулалт, хөнгөн үйлдвэрлэл
- ✓ Эрчимжсэн аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл, үйлчилгээ
- ✓ Аялал жуулчлал, соёлын өв хамгаалал, хөгжүүлэлт,
- ✓ Стратегийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл - нефть, эрчим хүч, хүнс
- ✓ Олон улсын тээвэр, ложистикийн төв
- ✓ Уул уурхайн оновчтой менежмент, байгальд ээлтэй хөгжил,
- ✓ Ногоон хот, агаарын бохирдолгүй аймаг
- ✓ Боловсролын чанараа, хүнээ ахиулах, хөдөлмөрт бэлтгэх
- ✓ Хариуцлагатай, чадавхитай засаглал
- ✓ Хүртээмжтэй, чанартай нийгмийн үйлчилгээ

ХОВД АЙМАГТ БҮЙ ҮНДСЭН ДАВУУ ТАЛУУД

Давуу тал 1. Хөгжлийн баруун үүд– бүсийн тулгуур төв

Монгол Улсын баруун бүс нутаг нь 500 км радиуст 20 сая хүн амтай 4 улсын тойрогт оршиж, БНХАУ, ОХУ, Казакстан улстай хиллэн, хойд урд хоёр их хөршийг холбосон Булган сумын Такешкан боомтоос Баян-Өлгий аймгийн Цагаан нуурын боомт хүртэлх 750 км орчим босоо тэнхлэгийн автозам, Мянганы замын хэвтээ тэнхлэг дайран өнгөрдөг, газар зүйн нэн тааламжтай бүс нутагт байрлаж байна.



Давуу тал 2. Олон ястны өлгий, өв соёлын голомт, оюунлаг түмний нутаг

Ховд аймгийн хүн амыг бүрдүүлж буй олон ястнууд нь өөрийн гэсэн нутгийн аялгуу, зан заншил, түүх соёлын өвөрмөц онцлогтой бөгөөд Монголдоо хамгийн олон ястан, угсаатан аж төрдөг, түүх соёлын нэн чухал өвүүдийг хадгалж ирсэн ард түмэн юм.

Давуу тал 3. Үржил шимт хөрс, газар тариалангийн өлгий нутаг

Ховд аймаг нь үржил шимт хөрс шороо, эрт дээр үеэс уламжлагдсан ирсэн тариа буудай, хүнсний ногоо, газар тариалан эрхлэлтээрээ улсдаа алдартай бөгөөд төмс, хүнсний ногооны 100 хувийг тус тус дотоодын үйлдвэрлэлээр хангаж байна.

Давуу тал 4. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн нөөцтэй

2019 онд аймгийн ДНБ-ны 40 орчим хувийг хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл бүрдүүлж байгаа бөгөөд 2018 онд 3,1 сая толгой мал тоолуулсан байна. Арьс шир, нэхий, ноос, ноолуур, мах, сүү, дайвар бүтээгдэхүүн, яс, дэл сүүл зэрэг бүхий л түүхий эдээ хаягдалгүй боловсруулан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг экспортлох, олон мянган ажлын байр бий болгох, орон нутгийн эдийн засгийг тэлэх, цаашлаад малын түүхий эдийн үнийг тогтвортой, үнэлэмжтэй байлгаж, малчдын орлого, ахуй амьдралыг сайжруулах боломжтой юм.

Давуу тал 5. Бизнес, хөрөнгө оруулалтын нэн тааламжтай орчин

Нийслэлээс 10 дахин бага татвар төлнө
Үл хөдлөхийн татвараас чөлөөлөгдөнө
Хямд эрчим хүч, түлш шатахуун хэрэглэнэ
Европын орнуудад 7200 нэр төрлийн барааг гаалийн татваргүй гаргана
Япон улсын зах зээлд 5700 нэр төрлийн барааг гаргах хэлэлцээртэй



Давуу тал 6. Хөгжлийн суурь дэд бүтэц сайн хөгжсөн

Монгол Улсын хэмжээнд хамгийн урт засмал замтай, хамгийн олон сум нь хатуу хучилттай замаар холбогдсон, Мянганы хөгжлийн хэвтээ босоо тэнхлэгийн олон улсад хүрэх зам харилцааны төв цэгт байрладаг нь маш том давуу тал юм.

Давуу тал 7. Сэргээгдэх эрчим хүчний нөөцтэй

Монгол орны хамгийн өндөр уулс, мөнх цаст ноён оргилуудын дийлэнх нь Ховд аймагт оршдог бөгөөд тэдгээрээс эх авсан олон зуун салаа гол мөрний эх ундарга болж байдаг.

Давуу тал 8. Байгалийн олон янз байдал, үзэглэнт, унаган төрх

Монгол орны алс баруун хязгаар Ховд аймаг нь байгалийн үзэглэнт тогтоц, гол нуурууд, өндөр сүрлэг уулс, түүх дурсгалт газрууд зэрэг аялал жуулчлалын баялаг нөөцтэй.

Давуу тал 9. Ашигт малтмал, байгалийн баялагийн нөөц

Ховд аймаг нь нүүрс, вольфрам, өнгөт металл, нефть, газрын ховор элемент, шохой, барилгын болон гоёлын чулуу зэрэг эрдэс баялагийн арвин нөөцтэй. 2006 оноос эхлэн аймгийн төдийгүй Баруун бүсийн хөгжилд ихээхэн чухал үүрэг гүйцэтгэх Хөшөөтийн нүүрсний уурхайг ашиглах төслийг хайна.



Баруун бүсийн нэгдсэн сүлжээ нь Увс, Ховд, Баян-Өлгий аймаг болон Говь-Алтай аймгийн баруун сумуудыг эрчим хүчээр хангаж байна. Баруун бүсийн нэгдсэн сүлжээний 2018 оны цахилгаан эрчим хүчний хэрэглээ нь 163,2 гаруй сая кВт/цаг байсан ба үүний 23,1%-ийг Дөргөний УЦС-аас, 73,1%-ийг ОХУ, БНХАУ-аас импортлосон, өндөр үнэтэй (Дөргөний УЦС-аас 6-7 дахин өндөр) эрчим хүчээр хангаж байгаа бөгөөд жил бүр улсаас 6-8 тэрбум төгрөгийн татаас олгож байна. Баруун бүсийн эрчим хүчний хэрэглээний өсөлт 2008-2016 онд дундажаар 8-11% өссөн. Цаашид 2020-2045 он хүртэл 208 сая кВт.цаг -408,6кВт.цаг өсөх төлөвтэй байна.

Эрдэнэбүрэнгийн УЦС ашиглалтанд орсноор:

- ✓ Баруун бүсийн аймгууд импортын цахилгаан эрчим хүчний хараат байдлаас гарна.
- ✓ Дотоодын хямд, найдвартай эрчим хүчээр хангагдана, баруун бүсийн эрчим хүчний системд олгодог 6-8 тэрбум төгрөгийн татаас тэглэгдэнэ.
- ✓ Эрчим хүчний найдвартай хямд эх үүсвэртэй болсноор гэр хорооллын айл өрхүүд цахилгаан халаалтыг нэвтрүүлж, агаарын бохирдол буурна.
- ✓ Эрчим хүчний өртөг зардал буурснаар бүс нутагт үйлдвэрлэл хөгжих, бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчдад тааламжтай нөхцөл бүрдэнэ.
- ✓ УЦС-ын барилгын ажлын үед 800-1000 хүн түр ажлын байраар, ашиглалтад орсны дараа 60-80 хүн байнгын ажлын байраар хангагдана.
- ✓ УЦС-ыг түшиглэн Эрдэнэбүрэн, Ховд, Буянт сумдад усалгааны системийг өргөжүүлж, шинээр нэмж байгуулах замаар газар тариалан эрхлэлт хөгжинө.
- ✓ УЦС-ын усан сангийн дагуу аялал жуулчлал, амралт зугаалгын үйлчилгээ, загасны аж ахуй хөгжүүлэх боломж бүрдэж, нутгийн иргэдийн орлогын эх үүсвэр нэмэгдэнэ.
- ✓ Жилд ойролцоогоор 756,6 мянган тонн нүүрс шатаасантай тэнцэх хэмжээний нүүрсхүчлийн хий ялгаралтыг бууруулна.
- ✓ Усан санд ихээхэн ус хуримтлуулснаар орчны агаарын чийгшил нэмэгдэж, орон нутгийн уур амьсгал, бэлчээрт эерэг нөлөө үзүүлнэ.
- ✓ Шижигтийн хавцалын загас түрсээ шахах боргиог байгалийн унаган төрхөөр нь хадгална.

2010.05.20

УИХ-ын 24-р тогтоолоор баталсан Ус үндэсний хөтөлбөрийн 3.3.20-т “Эрдэнэбүрэнгийн 64МВт усан цахилгаан станцын техник эдийн засгийн үндэслэлийг хянан үзэж, боломжтой тохиолдолд бусад усан цогцолборуудтай уялдуулж гүйцэтгэх”



2015.03.09

ЗГ-ын 86-р тогтоолоор Эрдэнэбүрэнгийн Ховд голд УЦС барих ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулж, хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх боломжийг судлах.



1960 он

ЗСБНХУ-ын

“Гидроэнергопроект” институтээс Техник-Эдийн засгийн тайлан боловсруулсан байдаг



2014.07.01

МУ-ын Эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 6.3-т “Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын усан цахилгаан станцыг барьж байгуулах бэлтгэлийг хангах, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулах, төслийн нэгж ажиллуулах” гэж заасан.

2015.06.19

2015 онд УИХ-аас баталсан Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого /2015-2030/-ын 4.1.1.4-т “Ховд гол дээр усан цахилгаан станц баригдсан байх” гэж оруулсан.



Төсөл хэрэгжүүлэгч: Эрчим хүчний яам
 Төслийг хэрэгжүүлэх хугацаа: 2018-2023 он
 Төслийн явц: ТЭЗҮ-г шинэчлэн боловсруулан, батлуулсан
 Хүчин чадал: 90МВт хүчин чадалтай, 1 жилд 300-325 сая кВт.цаг эрчим хүч
 Хөрөнгө оруулалтын хэмжээ: 288,5 сая ам.доллар



2017.05.31

МУ-н ЭЗ, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 5.3-т МУТХҮБ-2030-ын 2.1.5 ба Зорилт 2, ЗГҮАХ-н 2.100, ЭЗСХ-н 2.2.3 дахь заалтыг хангахад “Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийн барилгын ажлыг үргэлжлүүлэх”, үүнд Эрдэнэбүрэнгийн 64 МВт-ын УЦС-ын барилгын ажил

2019.09.18

Засгийн Газрын 357-р тогтоолоор Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц баригдах болон нуур үүсэх нутаг дэвсгэр 28000 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авч, хилийн заагийн эргэлтийн цэгийн солбилцол, талбайн хэмжээг батлан шийдвэрлэсэн.

2016.10.26

ЗГ-ын 121-р тогтоолоор МУЗГ-н 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.100.3-д Ховд голын УЦС-ыг барих 2017-2022 он.



2019.03.06

ЗГ-ын хуралдааны 10-р тэмдэглэлээр БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн үндсэн шаардлага болон үнэлгээний нөхцөлд нийцсэн ТЭЗҮ боловсруулах санал тавьсан компанитай хамтын ажиллагааны харилцан ойлголцлын санамж бичиг байгуулахыг Эрчим хүчний сайд Ц. Даваасүрэнд зөвшөөрөв



2016.12.28

ЗГ-ын 208-р тогтоолоор ЭЗ-ийг сэргээх хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөний 2.2.3.4-т Ховд голын 64МВт-ын УЦС урьдчилсан судалгаа, ТЭЗҮ-г хийж, барилга угсралтын ажлыг эхлүүлэх.



2018.05.30

ЗГ-ын 160-р тогтоолоор БНХАУ-н ЗГ-аас МУ-н ЗГ-т олгох нэг тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслүүдийн жагсаалтад “Эрдэнэбүрэнгийн УЦС барих” төслийг оруулах, БНХАУ-н ЗГ-т санал болгох.





“ХОВД ЭКО ЦЕМЕНТ”-ИЙН ҮЙЛДВЭР

Өнөөдөр Баруун бүсийн аймгууд УБ хотод зарагдаж байгаа үнээс 2 дахин өндөр үнэтэй цемент хэрэглэдэг. Энэ нь цементийн орцтой бүх зүйлд нөлөөлж, үнийг нь өсгөж байгаа бөгөөд тэр дундаа барилга, байгууламжийн үнэд хамгийн их нөлөөлдөг. Одоо Ховд аймагт 1м2 байрны үнэ 1,100,000-1,300,000 төгрөг байна. Ховд Эко цементийн үйлдвэр ашиглалтанд орсноор баруун бүсийн цементийн үнийг УБ хотын цементийн үнэтэй ижил түвшинд хүргэнэ. Ингэснээр 1м2 байрны үнэ дундажаар 37 хувиар буурна. Төслийн бусад ач холбогдлоос дурдвал:

- ✓ 250-350 байнгын ажлын байр бий болгоно.
- ✓ Улсын төсөвт ирэх 10 жилд 50-60 тэрбум төгрөгийн татварыг төвлөрүүлнэ.
- ✓ Орон сууцны үнийг бууруулж, ард иргэдийн амьдрах нөхцөл сайжирч, агаарын бохирдол буурна
- ✓ Тээвэрлэлтийн зардал 100% хэмнэгдэнэ.
- ✓ Баруун бүсийн томоохон бүтээн байгуулалтуудыг дэмжинэ.
- ✓ Бүсчилсэн хөгжлийн бодлого биелэлээ олно.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:
Вестерн Холд ХХК

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭМЖЭЭ: 60 сая ам.доллар

БАЙРШИЛ: Ховд аймгийн төвөөс 15 км, Буянт сумын төвөөс 8 км зайд Шохойт ордын дэргэд


ХЭРЭГЖИХ ХУГАЦАА:
2019-2020 он
ТӨСЛИЙН ЯВЦ: төлөвлөгөөний дагуу үйлдвэрийн ажил явагдаж байгаа.

ҮЙЛДВЭРИЙН ХҮЧИН ЧАДАЛ:
Чулуунцар: 1.000тн/хоног
250.000 тн/жил

Цемент: 300.000тн/жил



“ШИНЭ ХОВД” ОЛОН УЛСЫН НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ



2018 онд Ховд аймгийн “нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж ОУ-ын нисэх буудал болгох шийдвэр гарсан бөгөөд түүнээс хойш шаардлагатай судалгаанууд хийгдэж, бичиг баримтыг боловсруулсан. Ховд аймаг нь 4С ангиллын ОУ-ын нисэх буудалтай болох олон ач холбогдолтой юм.

Үүнд:

- ✓ Нисэхийн аюулгүй ажиллагааны хангалт сайжирч, олон улсын нислэгийн дэд бүтэц хөгжинө.
- ✓ Агаарын тээврийн хэрэгцээг хангаж, нислэгийн сүлжээ өргөжиж, агаарын тээврийн өрсөлдөх чадвар нэмэгдэж, орлого өснө.
- ✓ Орон нутгийн иргэд УБ хотоор дамжихгүйгээр зарим ОУ-ын нислэгүүдийг шууд Ховд аймгаас нисэх боломж бүрдэнэ.
- ✓ Ховд аймгаар аялах жуулчдын тоо өсч, аялал жуулчлалын салбарын хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ.
- ✓ МУ-ын агаарын замын хувьд Евро-Азийг холбосон ОУ-ын нөөц нисэх онгоцны буудалтай болно.
- ✓ Орон нутагт ажлын байр нэмэгдэнэ.

Аеродром нь ОУ-ын иргэний нисэхийн байгууллага /ICAO/-ын шаардлагыг хангасан 4С зэрэглэл бүхий Боинг 737, Аэробус 320, маягийн агаарын хөлөг хүлээн авах хүчин чадалтай байх бөгөөд зурвас нь голчийн гэрэлтүүлгийн системтэй байна. Харин нисэх буудлыг 2 хүзүүвчтэй, цагт 300-аас багагүй зорчигчдод үйлчлэх хүчин чадалтай байхаар тооцоолсон.

Төсөл хэрэгжүүлэгч: Зам, тээврийн хөгжлийн яам, Иргэний нисэхийн ерөнхий газар

Төсөл хэрэгжих хугацаа: 2020-2022 он

Төслийн нийт хөрөнгө оруулалт: **45.0 тэрбум төгрөг**

2019-2025 оны хооронд зорчигч тээвэрлэлт жилд дундажаар 10.9 %-ийн өсөлтэй байхаар тооцоолж 2025 онд зорчигчийн тоог 17500 хүргэхээр төлөвлөн ажиллаж байна.

ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР



Ховд аймагт газрын тос боловсруулах үйлдвэр барих 2018 оны 12 сард талаар яригдаж байсан бол өнөөдөр үйлдвэр барихтай холбоотой урьдчилсан бэлтгэл ажлууд болон бичиг баримт боловсруулалтын ажлууд хийгдэж дууссан. Мөн энэ ондоо үйлдвэрийн барилгын зураг төслийн ажлыг дуусгаж, 2020 оны 3-р сараас эхлэн үйлдвэрийн барилга угсралтын ажлыг эхлүүлэхээр төлөвлөжээ.



Газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтанд орсноор:

- ✓ Ховд аймгийн ард иргэд Улаанбаатар хоттой адил үнээр буюу тээвэрлэлтийн зардал нэмэгдээгүй хямд шатахуун хэрэглэнэ.
- ✓ Бензин, дизель түлшний үнэ буурснаар өргөн хэрэглээний болон бусад бараа бүтээгдэхүүний үнэ буурна.
- ✓ Импортыг орлох, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгдэнэ.
- ✓ 35 хүнийг байнгын ажлын байраар хангана.
- ✓ Гадаад руу гарах валютын урсгалыг бууруулна.
- ✓ Орон нутгийн төсөвт татвар төлнө.
- ✓ Үйлдвэрлэл бүтээн байгуулалтыг дэмжинэ.

Төсөл хэрэгжүүлэгч: “Трансгейт Интернэшнл ” ХХК

Төслийн зорилго: ОХУ-аас түүхий эд импортлон, дотооддоо боловсруулан, Монгол Улсын стандартад нийцсэн газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.

Үйлдвэрийн байршил: Ховд аймгийн Жаргалант сумын 1-р баг, Ямаат уулын өвөр сумын төвөөс 6 км зайд

Хөрөнгө оруулалтын хэмжээ: **15,9 тэрбум төгрөг**

Хүчин чадал: Жилд 50,000 тонн бүтээгдэхүүн

ОЛОН УЛСЫН ТЭЭВЭР, ЛОЖИСТИКИЙН ТӨВ

Ховд аймгийн ОХУ, БНХАУ, цаашлаад Евро Азийн зах зээлд гарах гол замуудын уулзвар цэгт оршдог, олон улсын чанартай авто замууд дайран өнгөрч байна. Гүний гаалийг байгуулж, хөгжүүлэх боломж бүрдэх ба олон тооны ажлын байр, баталгаат агуулахын үйлчилгээг үзүүлж, бүс нутгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэнэ.

- ✓ Ложистикийн төв, дэд төвүүдийг дагасан авто зогсоол, авто засвар, шатахуун түгээх станц, агуулах, зочид буудал, зоогийн газар, кафе, интернет, халуун ус, дэлгүүр зэрэг маш олон худалдаа, үйлчилгээ бий болж хөгжинэ.
- ✓ Олон иргэд ажлын байр, жижиг дунд бизнестэй болно.
- ✓ Орон нутагт үйлдвэрлэл хөгжих, бараа бүтээгдэхүүн экспортлох, импортоор түүхий эд авах, худалдаа, бараа эргэлт эрс нэмэгдэнэ.
- ✓ Транзит тээврийн зам ашиглалтын төлбөр хураамжаас орон нутгийн төсөвт төвлөрөх орлого нэмэгдэнэ.
- ✓ Байнгын ажиллагаатай хилийн боомтууд бий болно, бараа эргэлт, ажлын байр нэмэгдэнэ.



ЗАМ ДАГАСАН ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВҮҮД

Ховд аймаг дахь хэвтээ болон босоо тэнхлэгийн 1200 км гаруй олон улсын болон улс, орон нутгийн чанартай зам дагуу үйлдвэрлэл үйлчилгээ хөгжүүлэх боломжтой.

- ✓ Авто замын 200-250 км зай тутамд, авто замаас 50 метрээс багагүй зайд байрлах
- ✓ Ашиглалтын хугацаа 15 жилээс дээш байх
- ✓ Хөдөлгөөний аюулгүй байдал, байгаль экологид ээлтэй байх
- ✓ 24 цагийн ажиллагаатай
- ✓ Интернет, гар утасны сүлжээтэй
- ✓ Хоолны газар, зочид буудал, худалдаа, авто техникийн үйлчилгээ, шатахуун түгээх станц, авто зогсоол зэрэг цогц





ШИНЭ ХОВД ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК

Хөдөө аж ахуйн түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх үндэслэл:

1. Баруун бүсийн аймгуудад тулгуурласан түүхий эдийн бааз суурь сайтай
2. Малын гаралтай түүхий эдийн цэвэрлэх байгууламжтай
3. Хөрөнгө оруулалт, татварын таатай орчинтой
4. Хөрш зэргэлдээ улсууд болох Хятадын Шинжаан Уйгарын ӨЗО, Дорнод Казахстаны муж, ОХУ-ын Алтай, Тува, Япон болон Европын холбооны улсуудын зах зээлд бүтээгдэхүүнээ экспортлох боломжтой

УТП байгуулснаар бий болох ач холбогдол:

- ✓ Баруун аймгуудын нийгэм, эдийн засгийн хөгжил, өрсөлдөх чадварыг бий болгож дэвшилтэт техник технологи бүхий 18-20 үйлдвэр баригдана.
- ✓ Импортын бүтээгдэхүүний хэмжээ буурч экспорт өснө.
- ✓ Улсын болон орон нутгийн төсөвт төвлөрөх орлогын хэмжээ нэмэгдэнэ.
- ✓ 800-1000 хүний ажлын байрыг шинээр бий болгоно.
- ✓ Орон нутгийн түүхий эд бэлтгэн нийлүүлэгчид, малчдыг дэмжих бодлого хэрэгжинэ.
- ✓ Эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж, шинэ, дэвшилт технологид суурилсан, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл хөгжих үндэс суурийг бий болгоно.
- ✓ Эрдэм шинжилгээ, инноваци, шинэ технологийг судлах, нутагшуулах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлыг дэмжинэ.
- ✓ Жижиг, дунд үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ хөгжинэ

Төсөл хэрэгжүүлэгч: “Шинэ Ховд Үйлдвэрлэл, технологийн парк” ХХК

Байршил: Ховд аймгийн Жаргалант сумын Бичигт багийн үйлдвэрлэлийн бүс

Хөрөнгө оруулалтын эх үүсвэр: Дотоод, гадаадын хөрөнгө оруулалт

Хөрөнгө оруулалт: 45-50 тэрбум төгрөг

Үйлдвэрлэл технологийн паркид үйлдвэр байгуулснаар:

- Үл хөдлөх хөрөнгийн татвараас чөлөөлөх.
- Газрын татвараас чөлөөлөх.
- 1 хувийн орлогын албан татвара төлнө.
- Гадаадын хөрөнгө оруулагчид дэмжлэг үзүүлнэ.



Боловсруулах үйлдвэрлэл

- ☑ Арьс шир гүн боловсруулах үйлдвэр:

Сард 20,000 үхэр, 30,000 адууны шир, 80,000 богийн арьс

- ☑ Ноос, ноолуур угаах үйлдвэр:

Жилд 3000 тн боловсруулна.

- ☑ Ноос, ноолуур самнах:

Жилд 3600 тн угаасан ноолуур, 3800тн угаасан ноос.

- ☑ Хаягдал яс боловсруулах үйлдвэр:

Жилд 3000 тн боловсруулна.

- ☑ Дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр:

Өлөн гэдэсний 65%- ийг экспортонд гаргаж байна.

- ☑ Адууны дэл, сүүл боловсруулах үйлдвэр:

Сард 6 тн боловсруулна.

Хөнгөн үйлдвэрлэл

- ☑ Сүлжмэлийн үйлдвэр:

Жилд 30,000 ширхэг сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.

- ☑ Оёдлын үйлдвэр:

Жилд 50,000 ширхэг бэлэн хувцас үйлдвэрлэнэ.

- ☑ Оймс, бээлийний үйлдвэр:

Төрөл бүрийн оймс бээлий үйлдвэрлэнэ.

- ☑ Гутлын үйлдвэр:

Жилд 78,500 хос гутал үйлдвэрлэнэ.

- ☑ Савангийн үйлдвэр:

Хатуу болон шингэн саван, угаалгын нунтаг үйлдвэрлэнэ.

- ☑ Мод, модон эдлэлийн үйлдвэр:

Гэрийн болон барилгын модон хийцүүд үйлдвэрлэнэ.

- ☑ Сав баглаа, боодлын үйлдвэр:

Баруун бүсийн хэрэгцээг хангах картон хайрцаг, давуун болон цаасан уут, тор, бүх төрлийн шошго зэрэг 20 орчим нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.

- ☑ Дахин боловсруулах үйлдвэр:

Боловсруулах үйлдвэрийн хаягдал, ой модны хаягдал зах, з оргодос, мод бэлтгэх үйлдвэрийн хаягдал үртэс, хуш модны самрын яс, цэвэрлэх байгууламжийн лаг, дулааны цахилгаан станцын үнс, хоол хүнсний үйлдвэрлэл зэргийн хаягдлыг дахин боловсруулна.

Үйлчилгээ

- ☑ Ресторан, цайны газар
- ☑ Амралт, чөлөөт цагаа өнгөрөөх төв
- ☑ Хүнс барааны дэлгүүр
- ☑ Нэг цэгийн үйлчилгээ

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД НЭЭЛТТЭЙ



“ШИНЭ ХОВД АГРО ПАРК”- ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БҮС- ЦОГЦ ТӨСӨЛ

Ховд аймаг нь хүнсний ногоо тариалалтаар улсдаа дээгүүр ордог боловч, ХАА-ын бусад бүтээгдэхүүн болох сүү, цагаан идээ, мах, махан бүтээгдэхүүн, хавар өвлийн улиралд хүнсний нарийн ногоо, малын тэжээл, өндөг гэх мэт бүтээгдэхүүн нь улсын дунджаас 30-40 хувь өндөр үнэтэй байна. Төслийг хэрэгжүүлснээр гол нэрийн хүнсний бараа бүтээгдэхүүнээ улсын дундажтай адил буюу 20-40 хувийн хямд үнээр орон нутгийн иргэд худалдан авах боломж бүрдэхээс гадна экологийн эрүүл хүнс хэрэглэнэ.

Төсөл амжилттай хэрэгжих боломж:

- ✓ Дэд бүтцийн хөгжил сайн /зам, эрчим хүч /
- ✓ Худалдан авах зах зээл бэлэн /БНХАУ, ОХУ, Баруун бүс/
- ✓ Гадаргын усны нөөц хангалттай. /Ховд голоос усан сан байгуулах/
- ✓ Хөрсний үржил шим сайн /элсэрхэг хөрстэй/

Төсөл хэрэгжүүлэгч: Ховд агро парк ХХК

Төслийн байршил: Ховд аймгийн Буянт сумын Норжинхайрхан багт байрлах 1800 га талбай

Төсөл хэрэгжих хугацаа: 2018-2024 он

Төслийн явц: Богино хугацаанд 10 хувийн хэрэгжилттэй байна. Сүүний үхрийн 1ш ферм байгуулсан, Тэжээлийн үйлдвэр байгуулсан, 100 га талбайг бэлтгэсэн

Төслийн нийт хөрөнгө оруулалт: **20 тэрбум төгрөг**

УСАЛГААТАЙ ТАРИАЛАНГИЙН ТАЛБАЙГ НЭМЭГДҮҮЛЭХ



ХАМГААЛАГДСАН ХӨРСНИЙ ТАРИАЛАНГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ



ЭРЧИМЖСЭН АЖ АХУЙГ ХӨГЖҮҮЛЭХ



ДУНДЫН ҮЙЛЧИЛГЭЭ

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД НЭЭЛТТЭЙ

- Буянт суманд 600 га-ын усалтын системийг шинээр барих боловсруулах үйлдвэрийн зориулалтаар хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах.
 - Малын тэжээлийн үйлдвэр байгуулах. Мах, сүүний эрчимжсэн аж ахуйг шим тэжээл бүхий хүчит тэжээлээр хангана.
 - Бордооны үйлдвэр: Эко бордоогоор хангаж, эрүүл ногоо тариалалтыг бий болгох.
 - Тэжээл тариалалт, малын тэжээлийн үйлдвэрийн түүхий эдийг тариална.
 - Хүнсний ногоо тариалалт: Импортын бүтээгдэхүүнийг орлох хүнсний ногоог тариална.
-
- 10.000 кв.м өвлийн нарлаг хүлэмж байгуулах. Орон нутгийн иргэдийг жилийн 4-н улиралд шинэ ногоогоор хангана.
 - 10.000 кв.м зуны хүлэмж байгуулах. Орон нутгийн иргэдийг шинэ ургацын ногоор хангана.
 - 1000 кв.м үр, үрсэлгээ, суулгацын хүлэмж байгуулах. Баруун бүсийн аймгуудын тариалангчдыг үр үрсэлгээгээр хангана.
 - Үр, үрсэлгээ, сан: Өвөл, зуны хүлэмж болон усалгаатай талбайд тариалах тарималын үрийг тарина.
 - Сүүний үхрийн эрчимжсэн аж ахуйн тоог нэмэгдүүлэх Сүүний чиглэлийн 45 үнэтэй 4 ферм байгуулна. 1 ферм нь 600л/өдөр сүү нийлүүлж, сүүний зах зээлийн үнийг бууруулна.
-
- Махны чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуй: Жилд 30,000кг мах бэлтгэж, хэрэглэгчдэд нийлүүлнэ.
 - Хурга бордох аж ахуй: Жилд 90,000кг мах бэлтгэн экспортонд гаргана.
 - 500 гахайтай аж ахуй: Хэрэглэгчийг хямд үнэтэй шинэ гахайн махаар хангана.
 - 15,000 тахиатай аж ахуй: Орон нутгийн хэрэглэгчийг хямд үнэтэй, шинэ өндгөөр хангана.
 - Сүүний үйлдвэр: Хоногт 5000 л сүүг баруун бүсийн аймгуудад нийлүүлэх боломжтой.
-
- Техник дундын үйлчилгээ: Мэргэжлийн дундын үйлчилгээ бий болсноор тариалалт, тариа хураалтын үеэр бүтээмж нэмэгдэж, өртөг багасна.
 - Мэргэжлийн зөвлөх үйлчилгээ: Мэргэжлийн дундын үйлчилгээ бий болсноор тариалалт, тариа хураалтын үеэр бүтээмж нэмэгдэж, өртөг багасна.
 - Даршилсан ногооны үйлдвэр: УБ хотоос боловсруулсан бүтээгдэхүүн тээвэрлэх шаардлагагүй болж, орон нутагтаа бүтээгдэхүүнээ үйлдвэрлэнэ.
 - Механикжсан зорь: Мэргэжлийн дундын үйлчилгээ бий болсноор тариалалт, тариа хураалтын үеэр бүтээмж нэмэгдэж, өртөг багасна.



ГЭР ХОРООЛЛЫН ДЭД БҮТЦИЙГ ШИЙДЭЖ БАЙНА.

2018-2019 онд Жаргалант сумын Баатархайрхан, Бичигт, Тахилт багуудын нутаг дэвсгэрт 15 км цэвэр бохир усны шугам сүлжээний бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгээд байгаа ба төслийн хүрээнд шаардлага хангаж буй айл өрхүүдийг цэвэр, бохир усны шугам сүлжээнд үнэ төлбөргүй холбох ажлыг эхлүүлээд байна.

АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ЗОРИЛГООР ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ТӨСЛҮҮД

- Амины орон сууцны дахин дулаалга хийхэд үнийн хөнгөлөлт үзүүлэх
 - Дахин дулаалсан сууцыг цахилгаан халаалтанд шилжүүлэхэд үнийн дэмжлэг
 - Монгол гэрийн дахин дулаалгын хөнгөлөлт
 - Дахин дулаалсан Монгол гэрийг 1.5 кв хүчин чадалтай цахилгаан халаалтад шилжүүлэхэд үнийн хөнгөлөлт
 - Сайжруулсан соруулдаг ил жорлонгийн үнийн дэмжлэг
 - Цахилгаан шөнийн тарифт ухаалаг тоолуур суурилуулах
 - Жишиг гудамжны төсөл
- Гэр хороолол дундах жишиг сууцны төсөл

ЖИШИГ ГУДАМЖ ТӨСӨЛ

Аймгийн төвийн гэр хороолол байнга тэлж байгаагаас гудамжны зохион байгуулалт, өнгө төрхийг анхаарах шаардлага гарч байна. Иймээс Тахилт багийн 8, 9-р гудамжийг сонгон “Жишиг гудамж төсөл”-ийг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

“ТАХИЛТ ТАУН” бичил хотхон

Бие даасан дэд бүтэцтэй 12 айлын бичил хотхоныг гэр хорооллын 2 айлын газар дээр төлөвлөн хэрэгжүүлж эхлээд байна.

“ХАШААНДАА САЙХАН АМЬДАРЦГААЯ” ГЭР ХОРООЛЛЫН ДЭД БҮТЭЦ

Гэр хорооллын газрыг оновчтой зохион байгуулах, айл өрхүүдийг дэд бүтцээр хангах буюу цэвэр, бохир усны шугамд үе шаттай холбох замаар өөрсдийн хашаа, байшинд ая тухтай амьдрах нөхцөлийг нь бүрдүүлэх, ундны усны хангамжийг нэмэгдүүлэх, цаашлаад цахилгаан халаалтын систем нэвтрүүлэлтийг дэмжих, хотын агаарын бохирдлыг бууруулахад эерэг нөлөө үзүүлэхэд төслийн зорилго оршино.



2012 оноос эхлэн аймгийн төв Жаргалант сумын гэр хорооллын төв гудмуудаар цэвэр бохир усны шугам сүлжээ татах дэд бүтцийн томоохон төсөл эхэлсэн байдаг. Улмаар өнөөдрийг хүртэлх хугацаанд Алагтолгой, Баатархайрхан, Бичигт, Тахилт багуудад, 15 км урт цэвэр бохир усны шугам татаад байгаа бөгөөд тэдгээрээс богино (дунджаар 15-20м) зайнд айл өрхүүд хашаа, хувийн сууцруугаа салаалан, цэвэр бохир усны шугам оруулах ажлууд үргэлжилж байна.



ХОВД АЙМГИЙН СУМДАД БАРИГДАХ ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ТӨСЛҮҮД



ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД НЭЭЛТТЭЙ

- ✓ Эрдэнэбүрэн суманд 2000 га услалтын систем барих. Малын тэжээл болон бусад ашигт таримал (чихрийн манжин, эмийн ургамал), хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалж, дотоодын хэрэгцээг хангана.
- ✓ Алтай сумын Боомын амны 300 га газрын услалтын системийг сэргээн засварлах Боловсруулах үйлдвэрийн зориулалтаар хүнсний ногоо тариалж, баруун бүсийн аймгуудын хүнсний ногооны хэрэгцээг хангана.

Арьс ширний анхан шатны тордолтын үйлдвэр:

Сард 4,400 бод, 22,000 богийн арьс боловсруулна



Гар сүлжмэлийн үйлдвэр:

Жилд 5000 ширхэг “хэнд мэйд” бүтээгдэхүүн үйлдвэрлэж, экспортонд гаргана



Жимс, жимсгэнэ боловсруулах үйлдвэр:

Жилд 200тн жимс, жимсгэнэ тариалж, дотоодын хэрэгцээг бүрэн хангана



Сүүний үйлдвэр

Хоногт 5000л сүү нийлүүлнэ
Цөцгий 200кг, 500кг аарц боловсруулна
Жилд 145 хоног ажиллана



Сарлагийн сүүний үйлдвэр:

Хоногт 5000л сүү нийлүүлнэ
Цөцгий 200кг, 500кг аарц боловсруулна
Жилд 145 хоног ажиллана



Мал төхөөрөх үйлдвэр:

Хоногт 200 бод, 1000 бог төхөөрж, хэрэглэгчдийн шаардлагад нийцсэн мах, махан бүтээгдэхүүнийг нийлүүлнэ.



Хөнгөн блокын үйлдвэр:

Жилд 25,0 мян куб.метр хөнгөн блок үйлдвэрлэж, аймгийн барилга байгууламжийн хэрэгцээний барилгын блокыг нийлүүлнэ.



Төмөр хийцийн үйлдвэр

Жилд 5800м2 хашаа хайс, төмөр хаалга, карказ үйлдвэрлэж, орон нутагтаа хямд материал нийлүүлнэ.



ШИНЭ ХОВД



ХОВД АЙМАГТ КЕМБРИДЖИЙН СУРГАЛТТАЙ СУРГУУЛЬ БАЙГУУЛАХ

2019 оны ЕБС-ийн Боловсролын чанарын судалгаанаас харахад Кембриджийн сургалттай ЕБС-д суралцагчид үндэсний стандарттай сургуулийн суралцагчдийн дунджаас 2 дахин өндөр /60-аас дээш оноо/ амжилт үзүүлж байна. Энэ үзүүлэлтээр Ховд аймгийн 24 сургууль 19,2-45,6 оноо авч 21 аймгаас 16-д эрэмбэлэгдсэн. Энэ нь цаашид боловсролынхоо чанарыг сайжруулах бодлогыг төгөлдөржүүлэн, хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

360 сурагчтай Кембриджийн сургалттай сургууль байгуулах

Төслийн ач холбогдол:

- ✓ Олон улсын их, дээд сургуульд шууд элсэн суралцах боломжтой болно.
- ✓ Аймгийн нийт ЕБС-д загвар болох сайн туршлага нэвтэрнэ.
- ✓ Аймгийн ЕБС төгсөгчдийн сурлагийн амжилт дээшилнэ.

БАРУУН БҮСИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, ШИНЖЛЭХ УХААН, ИННОВАЦИЙН СУДАЛГААНЫ ТӨВ БАЙГУУЛАХ

- ✓ Мэдлэгт суурилсан бүтээгдэхүүний зах зээл бий болгож, бүс нутгийн аж үйлдвэржилтэнд шинжлэх ухааны үндэслэлтэй байгальд ээлтэй, эдийн засгийн үр ашигтай технологийг нэвтрүүлнэ.
- ✓ Судалгаа боловсруулалтын үр дүнд бий болсон мэдлэг туршлагыг эдийн засгийн эргэлтэнд оруулж инновацийн бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлнэ.
- ✓ Гарааны компаниуд тогтвортой үйл ажиллагаа явуулах тогтолцоог бүрдүүлнэ.
- ✓ Геологи, Нанотехнологи, Биотехнологи, Геоинформатик, Түүх-Археологи, Этнограф, Геохими, Радиоэкологи, Эрдэс судлал, Нийгмийн эрүүл мэнд судлал, Материал зэрэг шинжлэх ухааны суурь болон хавсарга (салбар) ухаанууд ХИС-ийг түшиглэн шинэ шатанд хөгжиж шинэ, дэвшилтэт болон өндөр технологи дамжуулах, нэвтрүүлэх, нутагшуулах өрсөлдөөнт үйлдвэрлэл хөгжүүлэх орчин бий болгох
- ✓ Бүсийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд хийгдэж байгаа бүтээн байгуулалтууд, тэдгээрийг дагалдсан биологийн олон янз байдал, хөрс, ус, агаар, эрдэс, ашигт малтмалын судалгааг хийснээр ашигт малтмалын нөхцөл, нөөц, бохирдол, олборлолт, ашиглалт хамгааллалтын мониторингийн системийг бүрдүүлэх

БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ТӨСЛҮҮД- ХӨГЖЛИЙН ТӨСӨЛ



ХОВД ИХ СУРГУУЛИЙГ ӨРГӨЖЛҮҮЛЭН, ХӨГЖҮҮЛЭХ

Баруун бүсийн ууган их сургуулийн хувьд хуримтлуулсан туршлага, нэр хүнд, нөөц бололцоондоо тулгуурлан хөгжлийн хөрөнгө оруулалтыг татаж, жил бүр өсөн нэмэгдэх баруун бүсийн ажиллах хүчний хэрэгцээг хангахуйц, боломжит мэргэжлүүдээр элсэлт авч, чанартай сургалттай, шилдэг менежменттэй “Шинэ Ховд их сургууль” болох.

Зорилтууд

01



Сургалтын хөтөлбөрт шинэчлэл хийх, ОУ-ын стандартын түвшинд хүргэх

02



Гадаад хамтын ажиллагаа хөгжүүлэх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх

03



Сургуулийн маркетингийн үйл ажиллагааг идэвхижүүлэх

04



Элсэгчдийн хүрээг гадаад, дотоод зах зээлд тэлэх бодлого баримтлах

05



Аж ахуй нэгж, байгууллагуудтай стратегийн түншлэл тогтоож Суралцагч оюутнуудыг дадлагажуулах, ажлын байраар хангахад бүх талаар хамтран ажиллах

06



Нийт багш ажилчид, оюутнуудын хандлагыг өөрчлөх, соёлыг төлөвшүүлэх

07



Хөдөлмөрийн зах зээлд ойрын ирээдүйд эрэлттэй байх мэргэжлүүдээр шинэ анги нээн хичээллүүлэх

Монголд ирж буй гадаадын жуулчдын 34 хувь нь байгаль, 24 хувь нь уламжлалт нүүдэлчдийн ахуй соёл, 12 хувь нь адал явдал, 11 хувь нь ан амьтан ажиглах, 10 хувь нь Монголын түүх, 9 хувь нь бусад шалтгаанаар аялдаг гэсэн судлаачдын дүгнэлт гарсан байна. Эдгээр сонирхлын 90 хувийг Ховд аймаг бүрдүүлэх нөөцтэй байна. 2018 онд гадаадын жуулчин-7199, дотоодын жуулчин-39781. Харин 2030 онд гадаад, дотоодын жуулчны тоог 65000 болгохоор зорилго тавин ажиллаж байна.

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ТӨВ

Байршил: Ховд аймгийн Жаргалант сум
Хэрэгжүүлэх хугацаа: 2020-2026 он
Ач холбогдол:

- ✓ Аялал жуулчлалын бодлогыг нэгдсэн байдлаар хамтран зохион байгуулж, өрсөлдөх чадварыг сайжруулна.
- ✓ Ажиллагсад, байгууллагуудын чадавх, зохион байгуулалт, харилцан хамтын ажиллагаа сайжрана.
- ✓ Олон улс, бүс нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах нөхцөл боломж сайжрана.
- ✓ Дэвшүүлсэн хөтөлбөр, зорилт амжилттай хэрэгжих нөхцөл бүрдэнэ.



ҮНДЭСТЭН ЯСТНУУДЫН ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН БҮХИЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЦОГЦОЛБОР

Байршил: Ховд аймгийн Жаргалант сум
Хэрэгжүүлэх хугацаа: 2020-2025 он
Төслийн ач холбогдол:

- ✓ Бүх шатны сургуулийн орон нутаг судлал, эх оронч үзэл, байгаль, түүхийн чиглэлийн хичээлүүдийн танилцах, дадлага хийх, судлах гол газрын нэг болно.
- ✓ Ховд аймгийг олон улс, дэлхийд суртачлан таниулах гол газар болно.
- ✓ Монгол орны нүүдэлчин ахуй соёлын гол бүтээгдэхүүн болно.
- ✓ Гадаад, дотоодын аялагчид, жуулчдын заавал очдог газрын нэг болно.
- ✓ Үндэсний үйлдвэрлэлээ дэмжинэ



ХИЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЦОГЦОЛБОР

Алтайн цаад говийн байгалийн үзэсгэлэнт байдал, Монгол Улсын дархан хилийг амиа хайрлахгүй хамгаалж байсан эрэлхэг баатруудын байгуулсан гавьяа, түүхт газрууд, торгууд, захчин, казак түмний ахуй амьдрал, түүх соёл дээр тулгуурлан танин мэдэхүйн болон тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх ач холбогдолтой, 1 ээлжинд 250 хүн хүлээж авах хүчин чадалтай цогцолбор.

Байршил: Ховд аймгийн Булган сум
Хэрэгжүүлэх хугацаа: 2019-2020 он
Ач холбогдол:

- ✓ Жуулчдын тоо нэмэгдэнэ.
- ✓ Эдийн засагт хувь зохих хувь нэмэр оруулна.
- ✓ Үндэсний үйлдвэрлэлээ дэмжинэ.
- ✓ Аялал жуулчлалын үргэлжлэх хугацааг уртасгах,



МӨНХ ЦАСТ УУЛ, ГОЛООР ЗАВИАР АЯЛАХ, ЗАГАСЧЛАХ ТУСГАЙ СОНИРХЛЫН БОЛОН ЭКО АЯЛЛЫН БААЗ



Ховд аймгийн мөнх цас, мөсөн гол бүхий өндөр сүрлэг уулсын байгалийн нөхцөл, өвөрмөц байгалийг түшиглэсэн аялал жуулчлалын бааз.

Байршил: Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Ховд сумдын нутаг

Хэрэгжих хугацаа: 2019-2026 он

Ач холбогдол:

- ☑ Ховд аймгийн мөнх цас, мөсөн гол бүхий өндөр сүрлэг уулсын байгалийн нөхцөл, өвөрмөц байгалийг аялал жуулчлалын салбарын эргэлтэнд оруулна.
- ☑ Уулын спорт, аялал жуулчлалыг хослуулан хөгжүүлнэ.
- ☑ Адал явдалт аяллын эхлэл тавигдана.



ХАР УС, ХАР, ДӨРГӨН НУУРТ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БААЗ

Ховд аймгийн байгалийн чухал орчин болсон нууруудын байгалийн нөхцөл, өвөрмөц байгалийг түшиглэсэн, 1 ээлжинд 100 хүн хүлээн авах хүчин чадалтай аялал жуулчлалын бааз.

Байршил: Ховд аймгийн Буянт, Дөргөн, Чандмань сумдын нутаг

Хэрэгжих хугацаа: 2019-2026 он

Ач холбогдол:

- ☑ Ховд аймгийн байгалийн чухал орчин болсон нууруудын байгалийн нөхцөл, өвөрмөц байгалийг аялал жуулчлалын салбарын эргэлтэнд оруулна
- ☑ Төв Азийн нүүдлийн шувуу, цэнгэг усны амьтан судлаач, сонирхогчдыг өргөнөөр татан оролцуулах боломж нээгдэнэ.
- ☑ Загас агнуурын спортыг хөгжүүлнэ.

ГУРВАН СЭНХЭРИЙН АГУЙ ТҮШИГЛЭСЭН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЦОГЦОЛБОР

40000 жилийн түүхтэй улсдаа төдийгүй, дэлхийд алдартай Гурван Сэнхэрийн агуйг түшиглэсэн, 1 ээлжинд 200 хүн хүлээж авах хүчин чадалтай аялал жуулчлалын цогцолбор.

Байршил: Ховд аймгийн Манхан сум

Хэрэгжих хугацаа: 2019-2027 он

Ач холбогдол:

- ☑ Цогцолбор байгуулснаар олон угсаатны бүлгүүдийн түүх соёл урлагийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, иргэдийн байгаль хамгаалах сэтгэлгээг нэмэгдүүлэх, эрүүл аюулгүй орчинд амрах, чөлөөт цагаа өнгөрөөх боломжтой болно
- ☑ Үндэсний үйлдвэрлэлээ дэмжинэ.





ХОВД ХОТЫН ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-2030 ХҮРЭЭНД ЭХНИЙ ЭЭЛЖИНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСЛҮҮД


ТӨСӨЛ-1 ХОТЫН ШИНЭ ТӨВ 22ГА



ТӨСӨЛ-2 ОРЛОГОД НИЙЦСЭН ОРОН СУУЦНЫ ХОРООЛОЛ 1,9 ГА



ТӨСӨЛ-3 АМИНЫ ОРОН СУУЦНЫ ЖИШИГ ХОРООЛОЛ 5,4 ГА





**ТӨСӨЛ-4 ГЭР ХОРООЛЛЫН
ДАХИН ТӨЛӨВЛӨЛТ 8,4 ГА**



**ТӨСӨЛ-6 ОЛОН УЛСЫН АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ЦОГЦОЛБОР 1,8 ГА**



**ТӨСӨЛ-5 ИНЖЕНЕРИЙН БЭЛТГЭЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД
ҮЕРИЙН ДАЛАН БАРИХ УСАН САН БАЙГУУЛАХ ТӨСӨЛ**



**ТӨСӨЛ-7 БУЯНТ ГОЛЫН
ЭРЭГ ДАГУУ АМРАЛТЫН БҮС**



**ТӨСӨЛ-8 МОД ҮРЖҮҮЛЭХ,
ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН**






ТӨСЛҮҮДИЙН ҮР ӨГӨӨЖ, АЧ ХОЛБОГДОЛ

- Ажилгүйдэл буурч, 2500 хүн байнгын, 1400 хүн түр ажлын байртай болно.
- Аймгийн эдийн засаг чадавхижиж, ДНБ-ний хэмжээ эрс өснө.
- Орон нутгийн төсвийн орлого нэмэгдэнэ.
- Стратегийн бүтээгдэхүүн болон нефть, эрчим хүчний импортоос хараат байдал арилна.
- Үйлдвэрлэл, үйлчилгээ, жижиг дунд, аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаа өргөжиж, бизнес эрхлэгчдийн тоо нэмэгдэнэ
- Бүтээгдэхүүн экспортлоно, инноваци, бүх төрлийн судалгаа шинжилгээний ажил өргөжин хөгжинө
- Малчид, тариалан эрхлэгчдийн орлого нэмэгдэж, байнгын тогтвортой байх нөхцөл хангагдана
- Эко болон этно аялал жуулчлал хөгжинө, соёлын өвөө хадгална, хамгаална, сурталчилна
- Аялал жуулчлал дагаж хөдөө орон нутгийн иргэд жуулчдад худалдаа, үйлчилгээ үзүүлэх замаар өрхийн орлогоо бий болно
- Орон нутагтаа үйлдвэрлэсэн экологийн эрүүл хүнс хэрэглэнэ
- Тээвэрлэлтийн өртөг зардал шингээгүй, хямд бараа бүтээгдэхүүнийг ард иргэд хэрэглэнэ
- Үндэсний үйлдвэрлэлээ дэмжинэ
- Бензин, шатахуун эрчим хүчний үнэ буурснаар хэрэглээний зардал, бараа бүтээгдэхүүний үнэ буурна
- Хямд цемент- хямд орон сууц, хямд эрчим хүч- цахилгаан халаагуур, агаарын бохирдол буурна
- Ажиллах хүчнээ дотооддоо бодлого хэрэгжинэ

АРД ИРГЭД, АЖ АХУЙ НЭГЖ, АЙМАГ ОРОН НУТАГ ХӨГЖЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ХАРИЛЦАН ШҮТЭЛЦЭЭ





“Шинэ ховд 2030” хөгжлийн төслүүд:

Санаачлагч:

УИХ-ын гишүүн, ТББХ-ны дарга, Ховд аймгийн Нутгийн зөвлөлийн дарга С.Бямбацогт

Хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлсэн:

Ховд аймгийн ИТХ

Ховд аймгийн ЗДТГ

Ховд аймгийн Жаргалант сумын ЗДТГ

Ховд аймгийн Нутгийн зөвлөл

Боловсруулсан:

“Шинэ ховд сан”-гийн ажлын хэсэг

Төсөл тус бүрийн санаачлагч, зохион байгуулагч, гүйцэтгэгч, ажлын хэсгийн гишүүд

УИХ-ын гишүүнийн Ажлын алба

2019 он